



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/197

Ховд


Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөнххайрхан сумын харьяат Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн 4 дүгээр курсын оюутан Э.Гантулгын Америкийн Нэгдсэн Улсад пара хөнгөн атлетикийн тэмцээнд оролцох замын зардалд 1.0 сая, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой Жаргалант сумын Хайрхан багийн иргэн Х.Мөнхцэцэг, А.Цоож нарт тус бүр 150000 төгрөгийн буцалтгүй тусламж тус тус олгосугай.

2. Буцалтгүй тусламжид олгох 1300000 төгрөг (нэг сая гурван зуун мянга)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ